

БАТЛАВ.....У.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН ГАДНА ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР



| № | Хийгдэх ажил, нэр төрөл | Тоо ширхэг | Тайлбар |
|---|-------------------------|----------------------------------|---|
| 1 | Тог татах | ыхн | 40 м тутам нэг шон байхаар 240 м газар 380в тог татна. Шон нь бетон хөлтэй модон тулгууртай, стандартын өндөртэй байх бөгөөд шон бүр гэрэлтүүлэгтэй байна. Тогийг стандартын сиф кабелиар холбоно. Цэцэрлэгт хүрээлэнгийн дотно монтажийг стандартын дагуу хийнэ. Стандартын тогийн хайрцаг, пускатель, тоолуур, цаг тохируулагч суурилуулж хайрцагт цоож хийсэн байна. |
| 2 | Гэрэлтүүлэг хийх | 10 ш | Гудамж талбайн зориулалттай стандартын гэрэлтүүлэг суурилуулна. Гэрэлтүүлгийн өндөр толгой нь талбайруугаа, намхан толгой нь гадагшаа харсан байхаар нэг гэрэл нь 150 вт-тай 3 ширхэг нүдэн гэрэлтэй байна. Гэрэлтүүлгийн шон нь төмөр, шинэ, цагаан өнгөтэй байна. Наадмын талбайн дөрвөн өнцөг, төв асрын 2 тал, төв хаалганы 2 талд, хажуу 2 талын голд нь тус бүр 1 ш нийт 10 гэрэлтүүлэг хийнэ. |
| 3 | Тугны суурь | 5м*0.5м хэмжээтэй, 0.6м өндөртэй | Суурь нь 1 м тутам 40-ын трубаг 1 м өндөртэй суулгаж цементэлнэ. Суурийг цементээр хийж цагаан өнгөөр эмульсээр будна. Суурь руу орох тугийн 5 ширхэг ишийг 7 м өндөртэй 32-ын трубагаар хийж алтлаг шар өнгийн бронзоор будна. Тугийн иш тус бүр туг өргөх татуургатай байна. |
| 4 | Нийтийн бие засах газар | 5 ш | 1 жорлон нь 4 тасалгаатай, 4м урттай, 1.2м өргөнтэй, 2м өндөртэй ногоон өнгийн төмрөөр хийнэ. Дээвэр нь 10 см уналттай налуу төмөр байна. Жорлонгийн рамыг 20*30 хэмжээтэй квадрат төмрөөр хийсэн байна. Хаалга нь 0.8м өргөнтэй 1.6м өндөртэй байна. Жорлонгийн шалыг 5 см-ын банзаар 2 м-ын урттай нягт шаллаж хаяаг нь цементэлсэн байна. Агааржуулагчтай, тасалгаа бүр хогны савтай байна. 4 тасалгаатай том жорлонгийн нүх нь 4 м, бусад 4 жорлонгийн нүх нь 2 м гүн байна. Жижиг 4 жорлон нь тус бүр 2 тасалгаатай дээд хэсгийн зөөвөрлөх боломжтойгоор хийнэ. Тасалгааны хэмжээ нь том жорлонтойгоо адил байна. 2 жижиг жорлонг морины газар барина. |


| | | | |
|---|---------------------------|---|--|
| 5 | Машины зогсоол | 4м*5м хэмжээтэй 550 машины зогсоол хийх | Наадмын талбайн хойно 132м*45м, 120м*15м, 52м*15м хэмжээтэй 15м-ээр тасалж хоёр тийшээ харж зогсохоор 350 машины зогсоол хийнэ. Наадмын талбайн урд буюу сургуулийн биеийн тамирын талбайн урд талд 60м*100м хэмжээтэй 60 метр талыг нь 15м-ээр тасалж хоёр тийшээ харж зогсохоор 200 машины зогсоол хийнэ. Хоёр зогсоол хоорондын зай 5 м байх ба нэг талын урсгалтай байна. Наадмын талбайн ард талын 350 машины зогсоол нь машин зогсох 4 м талд нь 3м-ын урттай 25-ын трубаг 3 тулгуур хөл/хөлийн өндөр газраас дээш 20см, доош 20 см-тай 20-ын труба/-тэй байхаар 2 талаас нь 0.5 м-ийн зайтай суулгаж 2 захад нь 5м урттай труба хийж дөрвөлжилж хийнэ. Зогсоолд хэрэглэх трубаны нийт урт нь 900 м байна. Трубаг улаан цагаан өнгөөр алаглаж будна. Зогсоол доторх зурвасыг цагаан өнгийн охроор будаж хийнэ. Сургуулийн биеийн тамирын талбайн урд талын зогсоолыг 4м тутам 5-ын банзаар газраас дээш 80см, газрын хөрснөөс доош 30 см байхаар шон суулгаж шонгийн дээд өнцөгт цоолж цагаан өнгийн бүдүүн олс татна. Шонг улаан цагаан охроор алаглуулж будна. Зогсоолын газрын хог чулууг түүж газрын гадаргууг тэгшилсэн байна. Зогсоолын палан зургийг хавсаргав. |
| | Морины газрын хязгаарлалт | 420 м | Газраас дээш 0.7м, газрын хөрснөөс доош 0.3 м байхаар 70 ш шургаа /5-ын банз байж болно/ шон 6 м тутам суулгана. Суулгасан шон хооронд бүдүүн олсоор хязгаарлалт хийж татсан байна. Шон дээр олс бэхэлж татах төмөр цагариг хийнэ. Шонг тод өнгийн охроор будна. |
| 6 | Дарцаг хийх | 15 ширхэг | Дарцаг нь 0.6м*1.5м хэмжээтэй, босоо байрлалтай, 2 талдаа Ховд сумын 100 жилийн лого, "Сайхан наадаарай" гэсэн бичигтэй байна. Дарцгийн өнгө нь тод олон янз байх бөгөөд Г хэлбэрийн 3.5 м урт төмөр иштэй байна. |

Боловруулсан:




..... ЗДТ-ын дарга Д.Лхагвасүрэн
 ЗД-ын орлогч дарга Ц.Рэнцэнсамбуу
 САалбаны дарга Ш.Нямсүрэн
 БОБЗХМэргэжилтэн Д.Сайнхүү
 ХЭХАХМэргэжилтэн Ц.Гантулга
 Нярав М.Тайван
 ХЖДҮХХМэргэжилтэн Э.Энхбат
 НБМэргэжилтэн Г.Амарзаяа
 Байгаль хамгаалагч Д.Мөнхөө
 ХААТ-н мэргэжилтэн Д.Батболд
 ХЭЗШҮДАХ мэргэжилтэн Д.Одончимэг
 Нягтлан бодогч Г.Нандинцэцэг

Зогсоолын палан зураг

1-р Зогсоол (Насууны талбайн ар талд)



66.



Нийт 350 машинны зогсоол

